

NOMADIC HERITAGE STUDIES MUSEUM NATIONALE MONGOLI



Tomus XIII
Fasciculus I- 39

НҮҮДЭЛЧДИЙН ӨВ СУДЛАЛ



Телеки Кристина*

**ӨНДӨР ГЭГЭЭН ЗАНАБАЗАРЫН БИЕТ БОЛОН
БИЕТ БУС ӨВИЙН ЖИШЭЭ БАРИМТУУД**

Анхдугаар Богд Жавзундамба Өндөр гэгээн Занабазар (1635-1723) нь монголын шарын шашныг үндэслэгч бөгөөд монголын шашин соёлыг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн. Түүний намтар болон үйл хэргийн тухай эрдэм шинжилгээний ном зохиол, өгүүлүүд монгол хэлээр, мөн гадаад хэлээр нилээдгүй судлаачдын бүтээлүүд гарсан. Энэхүү өгүүлэлд Өндөр гэгээний шашинтай холбоотой биет болон биет бус өвүүдийн тухай одоогоор надад олдсон баримтууд дээр тулгуурлан товчхон дурдахаас гадна Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй А-74, Д-1, 518 дугаартай Өндөр гэгээний бага насандаа эдэлж хэрэглэж байсан зүйлсийг дансалсан дансны тухай танилцуулах болно. Уг судалгааг Унгар улсын ОТКА PD 83465 ивээн тэтгэсэн. Тус өгүүллийг бичихэд туслалцаа үзүүлсэн Монголын Үндэсний Номын Сангийн эрдэм шинжилгээний ажилтан Ч.Гансүхэд гүн талархал илэрхийлье. Ц.Уранчимэгийн докторын ажил болох "Ikh Khъree: A Nomadic Monastery and the Later Art of Mongolia, 2009" хэмээх нэртэй бүтээл нь энэ сэдвийн дагуу судалгаа хийхэд их чухал ач холбогдолтой хэдий ч яг энэ өгүүллийг бичихэд надад олдоогүй учир ямар нэгэн мэдээлэл оруулаагүй болно.

1. Эд өлгийн зүйлс: Өндөр гэгээнтэй холбоотой түүхэн газрууд, сүм хийдүүд.

Өндөр гэгээнтэй холбоо бүхий Эрдэнэ-Зуу хийд болон өөр бусад түүхэн дурсгалт газрууд, түүний байгуулсан сүм хийдүүд нилээдгүй байдаг. Энэхүү газрууд нь монголчуудын дотор амнаас ам дамжин уламжлагдан ирсэн төдийгүй түүний үлдээсэн биет болон биет бус эд өлгийн зүйлсээр давхар нотлогдож байна. Эрдэнийн эрхи² хэмээх түүхийн бүтээлд дурдсанаар 1651 онд Төвдөөс 50 лам дагуулан ирж, Очирдар, Язгуурын таван бурхан болон өөр бусад бурхад шүтээнүүдийг бүтээж олон сүм хийдүүдийг үүсгэн байгуулжээ. Түүнтэй холбоо бүхий сүм хийдүүд 1930-аад он хүртэл үйл ажиллагаагаа явуулж байгаад их хэлмэгдүүлэлтийн үеэр зарим сүм хийдүүд нураагдаж, заримынхан үйл ажиллагааг зогсоосон бөгөөд 1990 онд ардчилсан хувьсгал ялснаар шашин шүтлэг чөлөөтэй болсноор тасарсан уламжлал дахин сэргэсэн.

Өндөр гэгээнтэй холбоотой түүхийн дурсгалт газар, сүм хийдүүдээс дурдая:³

- 1 Телеки Кристина. Өтвөш Лоранд Их сургуулийн Төв-Азийн тэнхимийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор(Ph.D)
- 2 Pozdneev A. M. Mongol'skaja letopis' "Erdeniin erihe". Materialy dlja istorii halhi 1636-1736. Sankt-Peterburg., 1883 тал 3-4.
- 3 Дэлгэлэнгүй мэдээллийг www.mongoliantemples.net; Croner D. Guidebook to Locates Connected with the Life of Zanabazar First Bogd Gegeen of Mongolia. Ulaanbaatar., 2006 тал 1-44.

- **Есөнзүйл:** Өндөр гэгээн Занабазар 1635 онд одоогийн Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын нутагт орших Есөнзүйл хэмээх газарт Чингис хааны алтан ураг Автай сайн хааны ач, Түшээт хан Гомбодорж, эх Ханджамцын хүү болон мэндэлжээ. Өндөр гэгээний хүйг дарсан газарт 1640 онд нэгэн суварга босгосон. Тус сувраганаас зүүн хойш хан Гомбодоржийн гэрийн буурь одоо хүртэл байдаг. Нэгэн домогт өгүүлснээр: Өндөр гэгээн мэндлэхэд есөн зүйлийн цэцэг зэрэг цэцэглэж, есөн зүйлийн рашаан булгилсан гэдэг. Есөнзүйлийн хурал нь тус газраас баруун урагшаа 500 метрийн зайд байгуулагдаж 1930 он хүртэл 100 орчим ламтай хурал хурж байсан тухай тус хийдэд шавилж байсан лам Ч.Жамба гуай хуучилсан. 2001 онд суврагын туурин дээр шинээр суврага, дуган барьсан.
- **Ширээт Цагаан нуур:** Өвөрхангай аймгийн Бүрд суманд орших Ширээт Цагаан нуурын эрэгт 1639 онд Занабазарт зориулан Өргөөг байгуулж, шашин төрийн тэргүүн анхдугаар богд хэмээн өргөмжилж хаан ширээнд залсан түүхэн газарт сүүлд 1999 онд гэрэлт хөшөө босгосон.
- **Шанхын баруун хүрээ** буюу Өвгөн хүрээг 1647 онд Өндөр гэгээн анх байгуулсан. Хийдийн танилцуулганд бичсэнээр Өвөрхангай аймгийн Хархорин сумын Шанх хэмээх газарт 1787 онд нүүн ирж 1930 гэхэд долоон аймагтай томоохон хүрээ болж өргөжсөн байжээ. 1990 оноос хойш үлдсэн гурван сүм дуганд хурал номоо сэргээж хурах болсон.
- **Төвхөн хийд:** Өндөр гэгээн Дүвхан/Төвхөн (Тө. sgrub-khang E-цам dga'-khyil) хийдийг Хангайн нуруу одоогийн Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Шивээт-Улаан ууланд байгуулсан. Тус хийдийг нураасан бөгөөд 1990-ээд онд дахин сэргээж улмаар 2004 онд ЮНЕСКО-гийн Дэлхий соёлын өвд бүртгэгдсэн түүхэн дурсгалт газрын нэг юм. Төвхөн хийдэд Өндөр гэгээнтэй холбоотой хэд хэдэн зүйл үлдсэн байдаг. Үүнд:
- Өндөр гэгээний бясалгалын агуй, түүний хадан дээрх гутлын мөр (Тө. zhabs), хадан сэнтий (Тө. seng khri), дахин сэргээсэн нямба хийдэг байсан дуган буюу бясалгалын сүм ба суварга, холбоо мод. Уг хийдийн шүтээнүүд нь Гомбо Махагал бөгөөд Дарь эхийг шүтдэг байв.
- **Сарьдагийн хийд, Зүүн хүрээ:** Зава лам Дамдингийн зохиосон Алтан дэвтэрт тэмдэглэсэнээр⁴ 1654 онд Өндөр гэгээн Хэнтийн нуруунд нүүж анхны Цогчин (Тө. tshogs chen) дуган, Ривогэжиганданшаддүвлинг (Тө. ri-bo dge-rgyas dga'-ldan bshad-sgrub gling) барьсан. Тус хийд нь Зүүн хүрээ (одоо Сарьдагийн хийд) хэмээн нэрлэж, нөгөө Өвгөн хүрээг (Шанхын хүрээ) Баруун хүрээ хэмээн нэрлэжээ. Сарьдагийн хийдийн туурь үлдсэн бөгөөд Төв аймгийн Мөнгөнморьт суманд буй Зүүн хүрээ 1930-аад он хүртэл хурал номоо хурж байжээ. Одоо дахин сэргээсэн

гэсэн 2 сурвалжаас үзнэ үү.

4 Lokesh Chandra (ed.). The Golden Annals of Lamaism. Hor chos-'byung of Blo- bzang rta-mgrin. 'dzam-gling byang phyogs chen-po hor-gyi rgyal-khams-kyi rtags-pa brjod-pa'i bstan-bcos chen-po dpyod-ldan mgu byed ngo-mtshar gser-gyi deb-ther zhes-bya-ba bzhugs-so. Zata-Piioaka Series. Vol. 34. New Delhi. 1964. 82v-83r.

дуган нь Багануурт байна.

- **Өргөө, Их хүрээ:** Улаанбаатар хотын үндэс суурь нь Өндөр гэгээний 1639 онд байгуулахдаа Өргөө хэмээн нэрлэсэн бөгөөд түүхэн хугацаанд Их хүрээ, Да хүрээ, Нийслэл хүрээ, Богдын хүрээ гэх мэтээр олон нэрлэгдэх болжээ. Эрдэнийн эрхид тэмдэглэснээр Х. Пүрэвжав⁵ О. Пүрэв нар⁶ Өргөөг Өндөр гэгээнийг амьд ахуй цагт нүүдэллэн газруудыг тэмдэглэн бичсэн байдаг: Ширээт цагаан нуур буюу Болов (1639), Хөшөө цайдам (1640), Сарьдагийн хийд (1654) Өгөөмөр (1688), Өвөр Монгол (1690), Цэцэрлэгийн Эрдэнэтолгой (1700), Дааган дуган (1719), Усан сээр (1720), Их тамир (1722), Жаргалант (1723). Богдуудын үед олон нүүсний эцэст 1855 онд Сэлбийн эрэгт суурьшсан байна. 1937-38 онуудад Богдын хүрээг бараг бүр мөсөн устгаж 1944 онд Гандантэгчилэн хийд, 1990 оноос Зүүн хүрээ Дашчойлин хийд болон бусад 50 гаруй сүм хийд үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийн ихэнх нь шинээр байгуулагдсан.
- **Амарбаясгалант хийд:** Өндөр гэгээний шарилыг хожим Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийдэд сувраглажээ. Суврагын дуган одоо ч байна. Гэвч доторхи шарилуудыг 1930-аад онд үед устгасан байна. Түүхий ороо бусгаа үед дуганууд нь бараг хэвээр үлдэж хоцорсон. 1990 оноос хурал номоо сэргээн хурах болсон.

Дээрхи баримтуудаас үзвэл Өндөр гэгээний үйл хэрэг Монгол улсын олон аймагтай (Өвөрхангай, Архангай, Хэнтий, гэх мэт) холбоотой байдгийг өнөө үеийн монголчууд мэддэг билээ. Иймээс түүнтэй холбоотой домог, түүх, биет болон биет бус эд өлгийн зүйлүүд Монгол даяар тархсан байна. Түүний байгуулсан сүм хийдүүд үе уламжлан хурал номоо хурсаар байгаад 1930 он хүрсэн хэдий боловч түүхий нугачаанд устгасан ч 1990 оноос дахин сэргээн хурал номоо хурсаар байна. Харин цаашдаа Өндөр гэгээний намтарт хэдэн онд аль түүхэн газарт ямар биет болон биет бус соёлын өв бүтээснийг судлах шаардлагатай байна.

2. Биет бус өв

Ламын гэгээн Лувсанданзанжанцан (1639-1704), Зая бандида Лувсанпирэнлэй (1642-1715), Өндөр гэгээн Занабазар зэрэг XVII зууны үед амьдарч байсан эрдэмтэн мэргэдүүд өнөөгийн Монголын бурхны шашны үндэс суурийг тавьсан байдаг. Түүхэн баримт, аман яриа зэргээс үзвэл Өндөр гэгээний анхлан бүтээсэн ёс жаяг нилээдгүй байна. Үүнээс доор дурдвал:

Хүрээ, аймаг, шанзодва, жас

Монголд сүм хийд, хүрээ, өртөө жас гэх мэтийн хурал номын газар орны нэрүүд одоогоор мэдэгдэж байна. Занабазар Төвдөөс буцаж ирээд Өргөөгийн эргэн тойрон долоон аймгийг байгуулж сүүлд дөрвөн аймаг нэмснээр нийт

5 Пүрэвжав С. Хувьсгалын өмнөх Их хүрээ. УБ., 1961 тал 19.

6 Пүрэв О. Улаанбаатар 360. УБ., 1999 тал 12.

11 аймагтай “хүрээ дэг”-ийг (Тө. sgrigs) үүсгэсэн байдаг. Тэр үед байсан 11 аймгийг нэрлэвэл: Сангийн аймаг (Сангайн аймаг), Зоогийн аймаг (Зоогийн аймаг), Жасын аймаг (тө. sryi-sa, аж ахуй), Дархан эмчийн аймаг, Андуу нарын аймаг (Төвдийн Амдо мужаас ирсэн буюу Төвдөөс ирсэн хүмүүс (лам нар)), Өрлөгүүдийн аймаг (Өрлүүдийн аймаг), Хүүхэн ноёны аймаг; Шүтээний аймаг, Сэцэн тойны аймаг, Баргын аймаг, Бандидын аймаг.⁷ Өндөр гэгээний сүүлд байгуулсан дөрвөн аймгийн хурлууд нь хуучин Монголд байсан улааны ёсыг (Нянмава, Сажава, Гармава) дахин сэргээжээ.

Анхны долоон аймгийн нэг нь Жасын аймаг (Тө. sryi-sa) нь мал аж ахуй, сүм дуганы засвар, бусад үйл ажиллагааг хариуцсан аймаг байсан. Энэ аймаг нь дараа дараагийн сүм хийдүүдэд жас байгуулах үндэс болсон бололтой. Г. Диваасамбуугийн бичснээр.⁸

Мөн Шанзодвын (Тө. rhyag-mdzod-pa) зохион байгуулалт нь Өндөр гэгээнтэй холбоотой байна. Анхны шанзодва, Дагвалхүндэв 1690-ээд оноос шанзодва болж Богдын сан буюу шавь нарын хэргийг эрхэлсэн.⁹

Цогчин дуган ба хурлууд

Ишбалдан,¹⁰ ЗаваламДамдин,¹¹ ДармадаалаDam-chosrgya-mtsho¹² ба А.М.Позднеев¹³ зэрэг эртэмтэд Өндөр гэгээнийг Ривогэжайганданшаддүвлин (Тө. ri-bo dge-rgyas dga'-ldan bshad-sgrub gling) Цогчин дуганыг 1654 онд анх байгуулсан хэмээн дурдсан байдаг. Х.Пүрэвжавын бичснээр¹⁴ Ривогэжайганданшаддүвлингийн тоосгон, модон дуганууд 1654-1680 онд баригдаад 1680 онд халх ойрдуудын дайны үед сүйтгэгдэж, 1706 онд Цэцэрлэгийн Эрдэнэтолгойд дахин байгуулагдсан бөгөөд түүнээс хойш Цогчин дуганг Батцагаан хэмээн нэрлэх болжээ. Харин Өндөр гэгээний байгуулсан Өргөөг хожим Их хүрээ хэмээн нэрлэх болсон.

Өндөр гэгээний байгуулсан Цогчин дуган Ривогэжайганданшаддүвлингийг өргөө буюу хүрээнд байгуулж өдөр тутмын цогчин уншлагатай болгосон

7 Сэрээтэр Ө. Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтцийн товч 1651-1938. УБ., 1999 тал 9.

8 Диваасамбуу Г. Тайвансайхан Д. Монголын Бурхан шашны түүхэн тойм. УБ., 2005 тал 89.

9 Сэрээтэр Ө. Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтцийн товч 1651-1938. УБ., 1999 тал 122-133.

10 Heissig W. Erdeni-yin erike. Mongolische Chronik der lamaistischen Klosterbauten der Mongolei von Ishibaldan (1835), Kopenhagen., 1961.

11 Lokesh Chandra (ed.). The Golden Annals of Lamaism. Hor chos-'byung of Blo- bzang rta-mgrin. 'dzam-gling byang phyogs chen-po hor-gyi rgyal-khams-kyi rtags-pa brjod-pa'i bstan-bcos chen-po dpyod-ldan mgu byed ngo-mtshar gser-gyi deb-ther zhes-bya-ba bzhugs-so. Zata-Pioaka Series. Vol. 34. New Delhi., 1964. 82v-83r.

12 Damchos Gyatso Dharmatāla. Rosary of White Lotuses, Being the Clear Account of How the Precious Teaching of Buddha Appeared and Spread in the Great Hor Country. Translated and annotated by Piotr Klafkowski, supervised by Nyalo Trulku Lobzang Rinpoche. Otto Harrassowitz. Wiesbaden., 1987 тал 338.

13 Pozdneyev A. M. Mongolia and the Mongols, edited by Krueger, J. R., translated by Shaw, J. R. and Plank, D., Bloomington., Indiana University. 1971 тал 44-45.

14 Пүрэвжав С. Хувьсгалын өмнөх Их хүрээ. УБ., 1961 тал 17.

байна. Түүнээс хойш байгуулагдсан сүм хийдүүдийн томоохон хүрээ хийдүүд Цогчин дугантай Цогчин уншлагатай болсон. Харин багахан газрууд Цогчин хуралтай байжээ. 1990 оноос хойш байнгын хуралтай газруудад Цогчин уншлагыг дахин сэргээсэн. Гэхдээ зарим газарт одоо хүртэл Цогчин уншлага байхгүй байна. Өөрөөр хэлбэл одоогийн шарын шашны хийдүүдийн цогчин уншлага нь Өндөр гэгээн Занабазараас уламжлалтай. Үүнийг өөрөөр болон Төвдөөс хамт ирсэн лам нар үүсгэсэн түүхтэй. Хурлуудын хувьд сар, жилийн дүйцэн өдрүүд Төвд гаралтай монгол онцлогтой хөгжсөн байна. Жишээлбэл:

Адислагын хуралд (Тө. *byin-rlabs*) цан 108 удаа цохиж адислага үйлдэх нь Өндөр гэгээнээс эхтэй юм. Мөн сахиусны хурал болон жилийн эцсийн хурал ном буюу хуучин хурлын хуучин, шинэ ян нь Өндөр гэгээний үүсгэсэн хуучин ян, тавдугаар Богдын (1815-1841) үед үүссэн шинэ ян зэрэг нь хоорондоо холбоотой. Мөн цогчин уншлагын ая дан, төвд үгүүдийг монголчлон уншдаг Өндөр гэгээн олон боть ном зохиосноос гадна, Жинлавцогзол (Тө. *byin-labs mchog-stsol*), Цэ таяа сог (Тө. *tshe mtha' yas sog*), Цагаан сарын хурлын Умлай даг (Тө. *om-las bgrang-yas*),¹⁵ болон Чогдон жамба буюу Бага Мандал Өндөр гэгээний зохиолууд болно.

Цогчин дуган буюу Батцагаан нь хүрээний төв хэсэгт орших бөгөөд дөрвөлжин хэлбэртэй, 108 баганатай, цагаан эсгийгээр бүрсэн бүрээстэй байжээ. Ийм загварын дуганы хэлбэр нь Өндөр гэгээний үеэс эхлэлтэй.

Дүйцэн өдрүүд, лам хувцас, ёс заншил

Одоо хурж байгаа жилийн дүйцэн (Тө. *dus chen*) өдрүүдийн зарим нь Өндөр гэгээнтэй холбоотой. Цагаан сарын 15 хоног хурдаг Чоймпрэл жүнай (Тө. *chos-'phrul bcu-lnga*) буюу Оройн ерөөл (Тө. *smon-lam*), Их ерөөл (Тө. *smon-lam chen-po*) Монголд анх хурсан нь Өндөр гэгээн Занабазартай холбоотой хэмээжээ.¹⁶ Монгол улсын Их ерөөл нь Төвдийн (Лхас хот)-ын дэгээс өөр байдаг. Монголд уншдаг нь зарим уншлага нь өөр. Өндөр гэгээний дэгээр (Тө. *sgrig*) уншдаг.¹⁷ Дармадаалаагын бичснээр¹⁸ Чоймпрэл жүнай болон Майдар эргэхийг (Тө. *byams-ra gdan-'dren*) анхлан 1657 онд Монголд хурсан түүхтэй. Мөн Эрдэнийн эрхид тэмдэглэснээр¹⁹ Эрдэнэ-Зуу хийдэд 1657 онд Даншигийг (Бат оршил, Тө. *brtan-bzhugs*) Өндөр гэгээнд өргөж, Их ерөөлийг хурж, Майдарыг эргэв хэмээн бичжээ..

15 Majer Zs. A Comparative Study of the Ceremonial Practice in Present-day Mongolian Monasteries, PhD dissertation, ELTE University, Budapest., 2008

16 Majer Zs. A Comparative Study of the Ceremonial Practice in Present-day Mongolian Monasteries, PhD dissertation, ELTE University, Budapest., 2008 тал 77.

17 Majer Zs. A Comparative Study of the Ceremonial Practice in Present-day Mongolian Monasteries, PhD dissertation, ELTE University, Budapest., 2008 тал 77.

18 Damchos Gyatso Dharmatāla. Rosary of White Lotuses, Being the Clear Account of How the Precious Teaching of Buddha Appeared and Spread in the Great Hor Country. Translated and annotated by Piotr Klafkowski, supervised by Nyalo Trulku Lobzang Rinpoche. Otto Harrassowitz. Wiesbaden., 1987 тал 339

19 Pozdneev A. M. Mongol'skaja letopis' "Erdeniin erihe". Materialy dlja istorii halhi 1636-1736. Sankt-Peterburg., 1883 тал 7.

Өндөр богдын дүйцэн ерөөлийг хаврын тэргүүн сарын 14-нд Хүрээний олон аймагт хурдаг байжээ. Одоо Гандантэгчэнлин хийд болон Зүүн хүрээ Дашчойлин хийдүүдэд одоо хүртэл хуучин ёсоор хурж байна.

Манж Чин улсын үед хуучин монгол дээлийн энгэрийг Өндөр гэгээн лам хүний дээлэнд, мөн лам нарын яриагаар зарим малгайн хэлбэрийг Өндөр гэгээн авч үлдсэн гэсэн аман яриа байдаг. А. М. Поздневийн тэмдэглэснээр²⁰ Өндөр гэгээн Цогчин хурлын хамба, цорж, гэсгүй, эрдэнэ чандмань унзад, болон “Тоохайн хувь” хэнгэрэгч бүгд Өндөр гэгээний үеийнх хэмээсэн байна. Үүнээс гадна Занабазарын тогтоосон дэг жаягын нэг нь Баруун хүрээнд хурал хурж байх үед гурван удаа хамрын тамхи тамхилдаг. Өглөө хурал эхлэхийн өмнө, манз дээр, хурал гадаалахад тамхилдаг байсан гэж лам нарын аман яриа байна.

3. Биет өв

Өндөр гэгээн Занабазар соёмбо болон Хэвтээ дөрвөлжин үсгүүдийг зохиож монголд хэрэглэж байсан бөгөөд одоогийн Монгол улсын далбаанд залагдахаас гадна Монголын Үндэсний Номын сангийн Үнэт ховор номын музейд энэ үсгүүдээр бичигдсэн судрууд хадгалагдаж байгаа хэдий ч яг Өндөр гэгээний үед бүтээгдсэн эсэх нь тодорхойгүй байдаг.

Монголын уран баримлын үндэс суурийг Өндөр гэгээн Занабазар тавьсан тухай Цүлтэм²¹ ийнхүү тэмдэглэжээ. Өндөр гэгээн Занабазар 1680-аад онд цутгамал бурхад олныг бүтээсэн байдаг. Жишээлбэл: Очирдар, Язгуурын таван бурхан, 21 дарь эх, Цэвэгмэд гэх мэтийн бурхадыг бүтээжээ. Мөн түүний бүтээсэн баримлуудыг Хүрээний аймгийн дугануудад Зуу, Авид, Намсрай, Манла, Барайшир зэрэгт хадгалагдаж байжээ. Өндөр гэгээний уран бүтээлүүдийг одоо музейнүүдэд хадгалагдаж буй учраас Өндөр гэгээн ба түүний үүсгэсэн ХҮII-ХҮIII зууны үеийн сургуулийн дэг жаяг Монголын уран баримлын талаархи баримтуудыг үзэх боломжтой байна.

Өндөр гэгээний Хүрээнд байсан бүтээлүүд

Өндөр гэгээний нандин шүтээнүүдийг хийсэн он, бүтээсэн газар одоо хүртэл тодорхойгүй. Харин 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн үеэс өмнө хадгалагдаж байсан газруудын зарим нь мэдэгдэж байна. Бага байхдаа лам байгаад хожим зураач болсон Д.Дамдинсүрэн номондоо²² Хүрээний таван нандин шүтээнийг дурджээ. Мөн Билгийн мэлмий²³ ба Northern Buddhist Conference хэмээх номонд²⁴ одоо Гандантэгчэнлин хийдэд хадгалагдаж байгаа шүтээнүүдийг бичжээ. Музейнүүдэд хадгалагдаж байгаа шүтээнүүдийн талаар Цүлтэм болон бусад бүтээлүүдээс гадна Mongolia: Museum Highlights

20 Pozdnevayev A. M. Mongolia and the Mongols, edited by Krueger, J. R., translated by Shaw, J. R. and Plank, D., Bloomington, Indiana University. 1971 тал 56.

21 Цүлтэм Н. Mongyol-un uran barimal. УБ., 1988. өмнөх үг

22 Дамдинсүрэн Д. Их хүрээний нэрт урчууд. УБ., 1995 тал 35-36.

23 Билгийн мэлмий., 2005 II сар № 15 (57), тал 3.

24 Northern Buddhist Conference on Ecology and Development. Ulaanbaatar., 2005 тал 285-286.

хэмээх өнгөтөөр хэвлэгдсэн эх сурвалж, англи хэлээр D. Croner номонд мөн дурдсан байна.

Д.Дамдинсүрэнгийн бичиж үлдээсэн Хүрээний таван шүтээн нь: Ганжуурын дуганд Аюуш буюу Цэвэгмэд/Цэгмид нь Өндөр гэгээний анхны бүтээсэн шүтээн мөн. Ихийн Ганжуурын өвгөн Аюушийн нэрээр мөн нэрлэдэг.²⁵ Одоо Гандан хийдэд бий.²⁷

Өндөр гэгээний бүтээсэн Ихийн Зуу Цогчин дуганы гунгарваан дуганд байлаа.²⁸ Одоо Гандан хийдэд бий.

Ноён шүтээний сүм буюу Маналын сүмд Манла бурхан шүтээнтэй байв. Одоо Ганданд бий.

Сосорбарам нь Өрлүүдийн аймагт байсан. 1973 оноос хойш Ганданд бий.

Их бурхан Очирдар бол Д.Дамдинсүрэнгийн тэмдэглэсэнээр²⁹ Шар ордонгийн Их бурханынх гэдэг гэр дуганд байв. Ө.Сэрээтэрийн бичсэнээр Зүүн хүрээний Очирдарийн сүм нь Өндөр гэгээний бүтээсэн хамгийн алдартай Очирдар буюу Очир баригч бурханыг агуулдаг байсан.³⁰ Их бурхан, Очирдар хоёр тус тусдаа байсан болов уу. Хэрвээ энэ хоёр тусдаа байсан бол хоёулаа Богдын Шар ордонд байсан байх гэсэн таамаглал дэвшүүлж байна.

Дээр дурдсан Их хүрээний таван нандингаас гадна Д.Дамдинсүрэнгийн тэмдэглэсэнээр³¹ Их хүрээний Дарь эхийнх, Далай ээжийн шүтээнийнх гэдэг мэт Өндөр гэгээний үед байгуулагдсан дуган, сүм, аймгуудад болон ялангуяа Очирдар гэдэг уран бүтээл нь голлож байжээ. Өргөөнд Жалба Рэгнаа (Targyal-ba rigs Inga) буюу Мижид, Одбагмэд (буюу Авид), Дондов, Намнан, Рэнжүн гэдэг язгуурын 5 бурхад тэргүүтэн хүрэл цутгамал байжээ. (Одоо Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей болон Чойжин ламын сүм бий). Мөн Өндөр гэгээний зурсан 45x35 см хавтгай дөрвөлжин буюу үзүүр тохой хэмжээтэй Цагаан Дарь эхийн загвар зургаар Их хүрээ 1924 оныг дуустал сар бүрийн шинийн найманд Цагаан Дарь эхийг өдөрт нь багтаан зурж бүтээдэг уламжлалтай байсан бөгөөд тэрхүү бүтээлүүд нь монголын томоохон музейнүүдэд хадгалагдаж байна.³²

Баруун өргөө буюу Автай сайн ханы өргөөнд лам нар Автай хан (1534-1589) болон Өндөр гэгээн Занабазар, Жамсран, Гомбо бурхадыг шүтэж байжээ. Өндөр гэгээний бүтээсэн Жамсран бурхан одоо Гандан хийдэд бий.

Дарь эхийн сүм буюу Цагаан Дарь эхийн сүм нь Ө. Сэрээтэр гуайн

25 Croner D. Guidebook to Locates Connected with the Life of Zanabazar First Bogd Gegeen of Mongolia. Ulaanbaatar., 2006 тал 44-55.

26 Дамдинсүрэн Д. Их хүрээний нэрт урчууд. УБ., 1995 тал 35.

27 Билгийн мэлмий., 2005 II сар № 15 (57), тал 3.

28 Дамдинсүрэн Д. Их хүрээний нэрт урчууд. УБ., 1995 тал 35.

29 Дамдинсүрэн Д. Их хүрээний нэрт урчууд. УБ., 1995. тал 37.

30 Сэрээтэр Ө. Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтцийн товч 1651-1938. УБ., тал 85.

31 Дамдинсүрэн Д. Их хүрээний нэрт урчууд. УБ., 1995 тал 36.

32 Дамдинсүрэн Д. Их хүрээний нэрт урчууд. УБ., 1995 тал 37.

тэмдэглэснээр³³ 21 Дарь эхийн шүтээнтэй байсан хэмээсэн байна. Одоо Ногоон Дарь эх тэргүүтэй 21 Дарь эх нь Богдын ордон музейд хадгалагдаж байна. Гэвч эдгээр шүтээнүүдийг Амарбаясгалант хийдийн шүтээнүүд байсан гэсэн аман яриа байдаг. Харин Цагаан Дарь эх нь Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд байдаг. Эдгээр шүтээнүүд нь Дарь эхийн сүмд байсан бололтой. Д.Дамдинсүрэнгийн дээр дурдсан номонд бичигдсэнээр³⁴ "Дарь эх гэдэг уран дүрүүд Их хүрээнд Богдын ордон өргөөний шар хашаанд тусгайлан хоёр давхар бэсрэг модон сүмийн гол байрыг эзэлж байсан. Одоо Богд хааны ордонд бий." хэмээн тэмдэглэжээ.

Мөн Чойжил буюу Чойжоо нь Их хүрээний Дондовлингийн аймагт буюу Зурхайн дацанд шүтэгдэж (Зурхайн Чойжоо) бөгөөд одоо Гандан хийдэд буй.

Баян Намсрай шүтээн нь Сангайн аймагт шүтэгдэж байсан бөгөөд одоо Гандан хийдэд буй.

Эх дагина аймагт Өндөр гэгээний сүм, жас байсан атлаа Өндөр гэгээнтэй холбоо бүхий эд өлгийн зүйлс байсан эсэх нь тодорхойгүй. Чойжин ламын сүм нь Хотол чуулганы тус амгалант тивийн сүм буюу Өндөр гэгээний сүм нь 1907 онд Өндөр гэгээний дурсгалд зориулан барьжээ. Одоо тус сүмд Өндөр гэгээний бүтээлүүд бий.

Одоогийн музей хийдүүдийн холбоотой агуулга

1937-1938 оны хэлмэгдүүлэлтийн үед Хүрээний олон шүтээнүүдийг устгасан. 1938 онд Чойжин ламын сүмд заримыг нь цуглуулан хурааж, заримыг нь Гандантэгчэнлин хийдийн хамба лам Н. Эрдэнэпил Гандан руу авч явсан, заримыг нь сүүлд Гандантэгчэнлин хийд хувь хүмүүсээс авсан байдаг. Заримыг нь музейнүүд салж нийлэхэд хуваагдсан байдаг.

- Гандантэгчэнлин хийд: Очирдар, Ихийн Зуу, Ганжуурын Аюуш, Оточ Манал/Манла, Дарь эх, Улаан сахиус (Жамсран), Сангийн Намсрай, Зурхайн Чойжоо, Өндөр гэгээний ээжийнхээ хүслээр хийсэн өөрийн бүтээл, 1973 онд ирсэн Өрлүүдийн Барайшир буюу Сосорбарам зэрэг бүтээлүүд хадгалагдаж байна.
- Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд Өндөр гэгээнтэй холбоо бүхий 15 гаруй шүтээн байна: Язгуурт таван бурхны дөрөв нь: Авид буюу Одбагмэд, Мижид, Намнан буюу Нанзад, Дондов; Цагаан Дарь эх, Манзшир, Бодь суврага, Оточ Манал (сургууль?). Мөн Занабазарын өөрийн хөрөг зураг, Хатан эх Ханджамцийн хөрөг зэрэг бүтээлүүд, Өндөр гэгээний мутрын дардас мөн хадгалагдаж байна.

33 Сэрээтэр Ө. Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтэцийн товч 1651-1938. УБ., 1999 тал 85.

34 Дамдинсүрэн Д. Их хүрээний нэрт урчууд. УБ., 1995 тал 36.



Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Нанзад бурхан

- Чойжин ламын сүм музей: Дэмчиггарва (юүмтай), босоо Майдаг, Доржсэмбэ, Минтүг, Ринжүн, Аюуш, Цагаан Дарь эх
- Богд хааны ордон музей: Ногоон Дарь эх тэргүүтэй 21 Дарь эх
- Museum of Asian Art: Жанрайсэг, Ринжүн³⁵

Өндөр гэгээний бүтээлүүдийг одоо нийслэл Улаанбаатараас гадна Өвөрхангай аймагт олж үзэж болно.

- Шанхын Баруун хүрээ: Өндөр гэгээний бүтээсэн Ногоон Дарь эх 2, Цагаан Дарь эх, Дарь эх, Логшир Жанрайсэг, Доржсэмбэ (?) зэрэг бүтээлүүд байна.
- Төвхөн хийдэд Занабазарын өөрийнх нь баримал хадгалагдаж байна.

Өндөр гэгээний хувцас, эдэлж хэрэглэж байсан эд зүйлс

Өндөр гэгээний хэрэглэж байсан зүйлс нь Их хүрээ, Эрдэнэ-зуу, Баруун хүрээ, Төвхөн, Амарбаясгалант хийд зэрэгт шүтэгдэж хадгалагдаж байсан..

1892 онд А. М. Позднеевийн тэмдэглэсэнээр³⁶ Өндөр гэгээний дэвсгэр

35 Croner D. Guidebook to Locates Connected with the Life of Zanabazar First Bogd Gegeen of Mongolia. Ulaanbaatar., 2006. тал 54-55.

36 Pozdneyev A. M. Mongolia and the Mongols, edited by Krueger, J. R., translated by Shaw, J. R. and Plank, D., Bloomington, Indiana University. 1971 тал 54-57.

олбог, малгай, түүний бүтээсэн бурхад, Төвдийн орноос авчирсан ном судрууд нь Их Хүрээний Цогчин дуганд хадгалагдаж байжээ.

Туул голын эрэгт байсан Богдын Цагаан сүм буюу Гунгаадэжидлин ордон дотор тусдаа Өндөр гэгээний сүм байсан.³⁷ Өвгөн Жамбалын ярьснаар³⁸ Өндөр гэгээний хувцас тэр сүмд хадгалагдаж байжээ. Жишээлбэл: Түүний дөрвөн саравчтай товь малгай болон улаан өнгөтэй томоохон монгол гутал, зун өмсдөг байсан дээл байв. Эдгээр хувцасуудыг нэг уутанд хийж, Өндөр гэгээний шуумал баримлын дэргэд хадгалдаг байжээ.

Хүрээний Маймаачэнгийн Дашсамданлин дацан (Тө. bkra-shis bsamgtan gling grwa-tshang) Өндөр гэгээний бага байхдаа өмсдөг байсан бойтог шүтээнтэй байсан³⁹.

8-р Богд Жавзундамбыг жанч халсны дараа Цагаан ордонд байсан зүйлсийг Ногоон ордонд шилжүүлсэн байдаг. Харин хөдөөний сүмүүдэд хөдөөний хүмүүс аваачиж өгчээ. Өндөр гэгээний хувцас, эдэлж хэрэглэж байсан эд зүйлсээс заримаас дурдвал:

- Богд хааны ордон музей: Манжийн Энх-Амгалан хааны бэлгэлсэн модон сандал, таж магнаг дээл (149x100cm) зэрэг эд өлгийн зүйлс байна.
- Монголын Үндэсний Музей: Өндөр гэгээн Занабазарын хэрэглэж байсан дөш, аяны тогоо, тогооний ширмэл уут.
- Баруун хүрээ: Өндөр гэгээний 3 настай байх үед өмсдөг байсан жижиг лам дээл, нэг хос жижиг цан, түүний бүтээсэн дархан ганлин бүрээ хадгалагдаж байна.
- Төвхөн хийд: Өндөр гэгээний хадан дээрх гутлын мөр (Тө. zhabs), хадан сэнтий (Тө. seng khri)
- Хэнтий аймгийн музей (Өндөрхаан хот): О.Баттуяа Хэнтий аймгийн музейн захирлын бичсэнээр Хэнтий аймгийн музейд Өндөр гэгээн Жинлавцогзол хэмээх ном зохиох үед гурван янзын бууг урчуудаар хийлгэсэн байна. Үүний улаан ороомогон бууг хутагт хувилгаадыг хамгаалахын үүднээс бүтээсэн шүтээн бөгөөд 2.05 см урт, 5 цэнгийн тугалган сумтай буу байжээ.⁴⁰
- Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Занабазар Музейд Өндөр гэгээний тухай жижигхэн үзэсгэлэн байна.
- Эрдэнэ-зуу: Дээлийн навсархай/ торгон Очирваань, хонх очир, 8 суврага үлдсэн бололтой.

Далай ээж ба Өндөр гэгээний бага насны зүйлүүд

Өндөр гэгээний түүх намтарт ээж Ханджамцаас гадна Өндөр гэгээнийг

37 Сэрээтэр Ө. Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтцийн товч 1651-1938. УБ., 1999 тал 88.

38 Bawden C. R. (transl., ed.) Tales of an Old Lama, The Institute of Buddhist Studies [Buddhica Britannica Series Continua VIII], Tring, U. K. 1997 тал 8-9., тал 686-687.

39 Дүгэрсүрэн Л. Улаанбаатар хотын түүхээс (2 дахь хэвлэл). УБ., 1999 тал 38

40 Баттуяа О. Нэгэн үзмэрийн тухай: Музейн мэдээлэл. 2012. VII. Сар., № 6. 31 тал. Билгийн мэлмий., 2005 II сар № 15 (57). тал 31

хөхүүлж өсгөсөн Сүүн Далай ээж, Авай ээж хоёр гэж бас дурдагдах байна. Ж.Чойнхорын тэмдэглэснээр⁴¹ Өндөр гэгээн энэ хоёр ээждээ олон янзын шүтээн өгч тэд нарт зориулж Дундговь аймгийн Адаацаг сумын Цахиуртын жасыг 1663 онд Авай ээжид, харин Төв аймгийн Баян-Өнжүүл суманд Далай ээжид тус тус бүтээжээ.

Зава лам Дамдин „Аврал итгэлт дээдийн эгч дүү хоёрын жасын гарлын тэмдэглэл оршвай” хэмээх зохиолдоо тус хоёр жасын үүсэл гарлыг дэлгэрэнгүй бичжээ. (Цаашдаа дэлгэрэнгүй үзвэл Монгол улсын их сургуулийн Монгол хэл соёлын сургууль, Эх бичиг-Алтай судлалын тэнхим. Зава Дамдины тус хэлээр бичсэн сүмбүмийн “Ка” ботид буй „Аврал итгэлт дээдийн эгч дүү хоёрын жасын гарлын тэмдэглэл оршвай” хэмээх зохиолын орчуулга эх бичгийн судалгаа хэмээх сэдвийг үзнэ үү. 2008 он Орчуулж бичсэн М.Үүрийнтуяа).

Далай ээжийн жас нь Богдын Их шавийн харъяа, нөгөө Авай ээжийн жас нь Үйзэн гүний хошууны харъяа байжээ. Дараа нь Далай ээжийн жас нь Хойтгойдын Лувсан тойны аймагтай нийлж Шүтээний аймаг нэртэй болсон хэмээжээ.

Их хүрээний Өндгөн сүргийн бэлчээр нь Богд болон богдын төрийн садангийн мэдэлд байжээ.⁴² Тэр нь Туул гол, Дунд гол хоёрын хооронд байв. Шаравпэлжээлин буюу Ногоон ордны хойт хэсэгт Сүүн далай ээжийн саднууд амьдардаг байжээ.


Мөн өөр нэгэн сурвалж мэдээнд Шүтээний аймаг нь Өндөр гэгээний байгуулсан аймгуудын нэг бөгөөд Өндөр гэгээний ээжийн (Далай ээж) шүтэж байсан Гомбо бурхныг залсан сүмийг барьсан бөгөөд үүнийг улбаалан Шүтээний аймаг хэмээн нэрлэсэн түүхтэй.⁴³ Д.Дамдинсүрэнгийн тэмдэглэснээр (1995, 41) “Шүтээний аймагт Далай ээжийнх гэдэг тусгай модон гэр өргөөтэй газар байсан бөгөөд энд Өндөр гэгээний бүр хүүхэд агуу цагийнх нь бүх түүх дурсгалын зүйлүүд байсан гэдэг юм.” Үүний баталгаа нь Үндэсний Төв Архивын Богд хаант үеийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа Эрдэнэ Шанзодвын яамны А-74, Д-1, 518 хадгаламжийн нэгж 1918 оны данс доорхи агуулгатай. Жич: Уг дансны бичигт хуучирсан үг хэллэг тааралдаж байгаа учир □ хаалтанд орчин үеийн үг хэллэгийг тэмдэглэв.

41 Чойнхор Ж. Өндөр гэгээн Занабазар. УБ., тал 59-60.

42 Пүрэв О., Монгол төрийн голомт, УБ., 2004 тал 25-29.

43 Сэрээтэр Ө. Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтцийн товч 1651-1938. УБ., 1998 тал 18-20.

Олноо өргөгдсөний наймдугаар он хаврын сүүл сард Далай ээжийн шүтээнийнхэд [шүтээнд] буй Өндөр гэгээнтний балчир дүрийн юмыг байцаасан данс



(1-р х.) Олноо өргөгдсний наймдугаар он хаврын сүүл сард Далай ээжийн шүтээнийнхэд [шүтээнд] буй Өндөр гэгээнтний балчир дүрийн юмыг байцаан байцаасан нь:

Тийзтэй булигар авдарт агуулсан

- өлгийний хайлс мод 1
- төмөр оломтой хавтгай сур 3, үүний 1 тасархай
- ширмэл ултай улаан торгон гадуур бойв [бойтог] 1 хос
- дотуур эсгий бойв 2 хос, үүний 1 торгон эмжээртэй
- булган хөвөө хадсан хуучин баримт [баривууч] 1, үүний өнгө элэгджээ
- үнэгэн титэм 1
- төвд цагаан цэхэм [цайвар] дэвсгэр 1
- элэгдсэн хүрэн торгон өнгө, хөх торгон дотортой баримтны тасархай 1 хэсэг
- мөн баримтны тасархай 1 хэсэг
- (2-р х.) цагаан давуу өнгөтэй үстэй гуудан /гуддан (?) дотортой банзал 1
- хадаг дээс уяасан жодвон⁴⁴ 1
- шар торго 1 хэсэг
- оосор хадсан шар зүй (?) сав 1
- шар хиаз магнаг 1 хэсэг
- цагаан хадаг зангиа 52

44 Сүхбаатар О. Монгол хэлний харь үгийн толь'. УБ., 1997 тал 104. Тө. cod-pan, манжлага, титэм, дамрын уяа.

- хөх хэв 1 ам
- бага гуулин толь 2
- шар улаан торгон бүрээстэй зангиа 9, үүний 1-нд пүрэв зангиа уяатай
- урагдсан хүрэн яндар⁴⁵ баримт 1
- бэсрэг нэхий 2 хэсэг
- орос улаан цэхэм [цайвар] дөрвөлжин дэвсгэр 1
- хөх магнаг хавтага 1, энэ цагаан даавуу боодолтой
- (3-р х.) магнаг ортой лавир 1
- рилбү 1 боодол
- шүд 1, энэ хагархай бөгөөд дунд нь хөндий рилбү мэт нэгэн жижиг цагаан юмтай буй
- цагаан шаазан таваг 1, энэ хагархай
- шинэ соном хадаг 1

Эдгээрийг агуулсан авдарны хуучин төвд Ца үсгийн тийз аймгийн дотор үл олодох тул, тус аймгийн их ламын хадгалан буй төвд Га үсгийн тийзээр тийздэв.

Цэхэм [цайвар] өнгө ширмэл эсгий бүрээстэй сул булигар авдарт агуулсан юм нь:

- эсгий жанч 1
- цагаан давуу банзал 1
- хонины ноос нилээд хэсэг, энэ мөн авдарны дотор давхар ширмэл бүрээстэй булигаар хайрцагтай
- бас ноос 1, эсгий уут
- сул ноос нилээд хэсэг
- шар торгон өнгөтэй цагаан шанхай (?) дотортой бүтээлэг 1, энэ сабянтай (?) модон ховдтой
- алттай дугуй цац Авид 1003, энэ цөм булигар авдартай
- алттай цац Гүнрэг 1013
- шаазан гангар 1, энэ торгон хавхагтай
- Өндөр гэгээний оюут 1, бага бүрчиг содтой (?)
- мөн зүүж таалсан сахиус буу 2
- пүрэв зангиа 1
- мөнгөн гэр бүхий урсгалтай хүрд 1, энэ мөнгөн дугуй хүрэн зандан иштэй

Эрдэнэ шанздавтаны тамгын газрын тэмдэг

Эрдэнэ шанздавтаны тамгын газрын тэмдэг дөрвөлжин улаан тамганы дардастай. Хар бэхээр муутуу цаасан дээр 25x25 см хэмжээтэй.

1918 оноос хойш аль эсвэл 1937-1938 оны их хэлмэгдүүлэлтийн шуургуанаар эдгээр хувцас эд өлгийн зүйлсийг хаана шилжүүлсэн эсвэл нуусан, устгасан тухай ямар нэгэн баримт одоо хүртэл тодорхойгүй хэвээр л байна. Үндэсний

45 Сүхбаатар О. Монгол хэлний харь үгийн толь. УБ., 1997 тал 232. Тө. g-yang-dar, "хишгийн торго" Сайн сайхан, энх эсэн, урт наслахын билгэдэл болгосон цагаан өнгийн нэгэн зүйл алчуур.

Төв Архивын Х-1, Д-6, 401 хадгаламжийн нэгж Гандан хүрээний сүм дуган ба хашаа байшингуудыг Дотоод яамнаас 28 онд (1938 он) албан газруудаадад шилжүүлсэн тухай актуудын дотор 28 он (1938) 10 сарын 14 (5-р х.) Зүүн хүрээний Шүтээний аймгийн барилгыг Засгийн газар Намын төв хорооноо шилжүүлсэн акт бий. Түүн дотор их дуган, том байшин, 2 дунд зэргийн байшин, шавартай модон гэр, модон гэр, үүдний саравч, хашаа 4 тал хаалга, саравчийг шилжүүлсэн гэсэн байна. Харин эдгээр шилжүүлсэн зүйлсийг цаашдаа хэрхсэн тухай огт мэдэгдэхгүй байна. Мөн дээрхи авдаруудыг хэнд өгсөн тухай цаашид хэрхэн алга болсон. Шүтээний аймагт шавилан сууж байсан одоогийн Гандан хийдийн лам Гончиг гуайн санаж буй зүйлсийг нь энд дурдав. Тэрээр Шүтээний аймаг дотор Далай ээжийн дуганд олон хүүхэд шуугисан газар байсан. Тэнд Өндөр гэгээний эд зүйлс байсан болов уу миний санаж байгаагаар бөмбөгөр оройтой малгай байсан хэмээн ярьж билээ.

Өндөр гэгээнтэй холбоотой зүйлс хувь хүмүүсийн гар дээр нилээдгүй учир энэ өгүүлэлд тэр бүрийг оруулах боломжгүй байлаа. Мөн зарим бүтээлүүд нь түүний бүтээл үү аль эсвэл түүний шавь нарынх уу гэдгийг мэдэхэд хэцүү. Учир нь түүний бий болгосон бурхан бүтээх дэг жаягийг хойчийн шавь нар уламжлан залгамжилсан байдаг. Эдгээр бага байхдаа хэрэглэж байсан үнэт зүйлсийг хэрэв олдвол Монгол улсын үнэт ховор өвийг баяжуулах чухал эд өлгийн зүйлс билээ.

Шүтээний нэр одоо хадгалагдаж байгаа газар	Төвд нэр	Санскрит нэр	Хүрээнд хадгалагдаж байсан сүм	хэмжээ (см)
Гандантэгчэнлин хийд				
Очирдар	rdo-rje 'dzin-pa	Vajradhara	Их бурхных / Очирдарийн сүм	
Зуу	jo-bo	Zākyamuni Buddha	Их жас / Цогчин дуган	
Аюуш / Цэвэгмэд/ Цэгмид	tshe-dpag-med	Amitāyus	Ганжуурын дуган	
Манал/Манла	sman-bla	Bhaieajyaguru	Ноён шүтээний сүм	
Дарь эх	sgrol-ma	Tārā	Дарь эхийн сүм	
Улаан сахиус (Жамсран)	lcam-sring / beg-tse		Баруун өргөө	
Барайшир / Сосорбарам	so-sor 'brang-ma	Mahāpratisarā	Өрлүүдийн аймаг	
Намсрай	rnam-(thos)-sras	Vaizravaya/Kuvera	Сангайн аймаг	
Чойжоо	chos-rgyal	Yama	Дондовлин аймаг / Зурхайн дацан	
Өндөр гэгээн Занабазар				
Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей				
Авид / Одбагмэд	'od-dpag-med	Amitābha	Их бурхных / Очирдарийн сүм	71.4 x 44.5
Мижид	mi bskyod	Akeobhya	Их бурхных / Очирдарийн сүм	72 x 46
Намзад / Намнан	snang-mdzad	Vairocana	Их бурхных / Очирдарийн сүм	72 x 46
Дондов	Don yod grub pa	Amoghasiddhi	Их бурхных / Очирдарийн сүм	72 x 44
Цагаан Дарь эх	sgrol dkar	Sitatārā		68.9 x 44.8
Манзшир	jam-(dpal)- dbyangs	Macjuзrn		57.8 x 20
Бодь суврага	byang-chub mchod-rten	Bodhi stūpa		72 x 45
Өндөр гэгээн Занабазар (хөрөг зураг)				50 x 65
Хатан эх Ханджамц (хөрөг зураг)				42 x 57
Манал/Манла	sman-bla	Bhaieajyaguru		30 x 19

Чойжин ламын сүм музей				
Майдар	byams-pa	Maitreya		72 x 21 x 13
Дэмчиггарва (юүмтай)	bde mchog dkar-po	Sitasaxvara		54.5 x 33.8
Доржсэмбэ / Базарсад	rdo-rje sems-dpa'	Vajrasattva		70 x 50 x 30
Минтүг	mi-'khrugs	Akeobhya		35 x 20 x 20
Ринжүн	rin 'byung	Ratnasamhava	Их бурхных / Очирдарийн сүм	70 x 30 x 24
Аюуш	tshe-dpag-med	Amitāyus		48 x 52 x 31
Цагаан Дарь эх	sgrol dkar	Sitatārā		41,4 x 27 x

Дондов	Don yod grub pa	Amoghasiddhi	Их бурхных / Очирдарийн сүм	72 x 44
Цагаан Дарь эх	sgrol dkar	Sitatārā		68.9 x 44.8
Манзшир	jam-(dpal)- dbyangs	Macjuzn		57.8 x 20
Бодь суврага	byang-chub mchod- rten	Bodhi stūpa		72 x 45
Өндөр гэгээн Занабазар (хөрөг зураг)				60 x 66
Хатан эх Ханджамц (хөрөг зураг)				42 x 67
Манал/Манла	smān-bla	Bhaleajyaguru		30 x 10

Чойжин ламын сүм музей				
Майдар	byams-pa	Maitreya		72 x 21 x 13
Дэмчиггарва (юүмтай)	bde mchog dkar-po	Sitasaxvara		54.5 x 33.8
Доржсэмбэ / Базарсад	rdo-rje sems-dpa'	Vajrasattva		70 x 50 x 30
Минтүг	mi-'khrugs	Akeobhya		35 x 20 x 20
Ринжүн	rin 'byung	Ratnasamhava	Их бурхных / Очирдарийн сүм	70 x 30 x 24
Аюуш	tshe-dpag-med	Amitāyus		48 x 52 x 31
Цагаан Дарь эх	sgrol dkar	Sitatārā		41,4 x 27 x 40.18
Богд хааны ордон музей				
Ногоон Дарь эх тэргүүтэй 21 Дарь эх	sgrol ljang, sgrol ma	Śyāmatārā, Tārā		42.5 x 27
Museum of Asian Art				
Жанрайсэг	spyān-rās-gzigs	Avalokiteśvara		57 cm
Ринжүн	rin 'byung	Ratnasamhava		60 cm
Төвхөн хийд				
Өндөр гэгээн Занабазар				
Баруун хүрээ				
Ногоон Дарь эх	sgrol ljang	Śyāmatārā		
Ногоон Дарь эх	sgrol ljang	Śyāmatārā		
Цагаан Дарь эх	sgrol dkar	Sitatārā		
Дарь эх	sgrol-ma	Tārā		
Логшир Жанрайсэг	'jig-rten dbang- phyug	Avalokiteśvara		
Доржсэмбэ / Базарсад	rdo-rje sems-dpa'	Vajrasattva		

SUMMARY

The present article describes some of the tangible and intangible religious heritages related to Цндүр геgegen Zanabazar. First, some monastic sites are mentioned as "cradles" of his heritage. As intangible heritage Undur gegegen's role in the establishment of monastic administration, everyday chanting, and special festivals are emphasized. As tangible heritage the wonderful sculptures he prepared and some of his personal belongings are summarized here, though the list is not complete as there are artifacts and personal belonging possessed by private collectors. Moreover, a significant document (No. A-74/D-1/518) preserved in the National Archives of Mongolia is described here. It was written in 1918, and lists the personal belongings of Undur gegegen Zanabazar's childhood, such as cloths and religious objects. These objects were kept in boxes in Shuteenii aimaг of Ikh Khuree in 1918, but their further history is unknown.

АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ, ЭХ СУРВАЛЖ

Үндэсний Төв Архив, А-74, Д-1, 518: Олноо өргөгдсөний наймдугаар он хаврын сүүл сараг Далай ээжийн шүтээнд буй Өндөр гэгээнтний балчир дүрийн юмыг байцаасан данс (1918)

Үндэсний Төв Архив, Х-1, Д-6, 401: Гандан хүрээний сүм дуган ба хашаа байшингуудыг Дотоод яамнаас 28 онд албан газруудаадад шилжүүлсэн тухай актууд (1938)

МОНГОЛ ХЭЛНИЙ ЗОХИОЛУУД:

Баттуяа О. Нэгэн үзмэрийн тухай: Музейн мэдээлэл. 2012. VII. Сар., № 6. 31 тал
Билгийн мэлмий., 2005 II сар № 15 (57)

Бямбаа Р. Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл.
УБ., 2004

Дамдинсүрэн Д. Их хүрээний нэрт урчууд. УБ., 1995

Диваасамбуу Г. Тайвансайхан Д. Монголын Бурхан шашны түүхэн тойм. УБ., 2005

Дүгэрсүрэн Л. Улаанбаатар хотын түүхээс (2 дахь хэвлэл). УБ., 1999

Пүрэв О. Улаанбаатар 360. УБ., 1999

Пүрэв О., Монгол төрийн голомт, УБ., 2004

Пүрэвжав С. Хувьсгалын өмнөх Их хүрээ. УБ., 1961

Сүхбаатар О. Монгол хэлний харь үгийн толь. УБ., 1997

Сэрээтэр Ө. Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтэцийн товч 1651-1938. УБ., 1999

Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966

Цүлтэм Н. Monggol-un uran barimal. УБ., 1988

Чойнхор Ж. Өндөр гэгээн Занабазар. УБ.

ГАДААД ХЭЛНИЙ ЗОХИОЛУУД:

Bawden C. R. (transl., ed.) Tales of an Old Lama, The Institute of Buddhist Studies [Buddhica Britannica Series Continua VIII], Tring, U. K. 1997

Croner D. Guidebook to Locates Connected with the Life of Zanabazar First Bogd Gegegen of Mongolia. Ulaanbaatar. 2006

Damchos Gyatso Dharmatāla. Rosary of White Lotuses, Being the Clear Account of How the Precious Teaching of Buddha Appeared and Spread in the Great Hor Country. Translated and annotated by Piotr Klafkowski, supervised by Nyalo Trulku Lobzang Rinpoche. Otto Harrassowitz. Wiesbaden. 1987

Heissig W. Erdeni-yin erike. Mongolische Chronik der lamaistischen Klosterbauten der Mongolei von Ishibaldan (1835), Kopenhagen. 1961

Lokesh Chandra (ed.). The Golden Annals of Lamaism. Hor chos-'byung of Blo- bzang rta-mgrin. 'dzam-gling byang phyogs chen-po hor-gyi rgyal-khams-kyi rtags-pa brjod-pa'i bstan-bcos chen-po dpyod-ldan mgu byed ngo-mtshar gser-gyi deb-ther zhes-bya-ba bzhugs-so. Zata-Pixoka Series. Vol. 34. New Delhi. 1964

- Majer Zs. A Comparative Study of the Ceremonial Practice in Present-day Mongolian Monasteries, PhD dissertation, ELTE University, Budapest. 2008
- Mongolia: Museum Highlights, Important Work of Art from the Collection of the Zanabazar Museum of Fine Arts, Bogd Khan Palace Museum, and Choijin Lama Temple Museum. Ulaanbaatar-San Francisco, 2005
- Northern Buddhist Conference on Ecology and Development. Ulaanbaatar. 2005
- Pozdneev A. M. Mongol'skaja letopis' "Erdeniin erihe". Materialy dlja istorii halhi 1636-1736. Sankt-Peterburg, 1883
- Pozdneev A. M. Mongolia and the Mongols, edited by Krueger, J. R., translated by Shaw, J. R. and Plank, D., Bloomington, Indiana University 1971.
- www.mongoliantemples.net